



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/406

Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд
гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах
заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1,13, 30 дугаар зүйлийн 30.1.4, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах зааврыг хавсралтаар баталсугай.

2. Зааврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гамшгаас хамгаалах сургалтын газар (хурандаа Х.Сүхбаатар), төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (хурандаа Ц.Уранчимэг)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
А/... дугаар тушаалын хавсралт
1406.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд гамшгаас хамгаалах ойлголт, мэдлэг олгох сургалт (цаашид "гамшгаас хамгаалах сургалт" гэх)-ыг зохион байгуулах арга, хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг тодорхойлоход энэхүү зааврын зорилго оршино.

1.2.Зааврыг хэрэгжүүлэхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, Ази Номхон далайн бүсийн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн "эрхийг бодит болгох" Инчеоны стратеги, Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3.Энэхүү зааврыг харааны, сонсголын, хөдөлгөөний, оюуны болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэднийг асарч буй гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдад гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахад ашиглах ба төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн ангиллын сургалт хариуцсан мэргэжилтэн, төрийн болон төрийн бус байгууллага, сургалтын төв, орон нутгийн удирдлагад хамаарна.

Хоёр.Нэр томъёоны тодорхойлолт

2.1."Хөгжлийн бэрхшээл" гэж бие эрхтний бэрхшээлтэй хүнд хандах хандлага, хүрээлэн буй орчны саад бэрхшээлээс шалтгаалан бие эрхтний бэрхшээлтэй хүн нь бусад хүмүүстэй тэгш эрхтэйгээр нийгэмд бүрэн дүүрэн, үр ашигтай оролцож чадахгүй байхыг;

2.2."хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар ойлгоно;

2.3."Сонсголын бэрхшээлтэй хүн" гэж сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;

2.4."Хэл ярианы бэрхшээлтэй хүн" гэж хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний "ярих", "харилцах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;

2.5."Харааны бэрхшээлтэй хүн" гэж харааны эрхтний гэмтэл, согогийн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй болсон хүнийг;

2.6."Хөдөлгөөний бэрхшээлтэй хүн" гэж биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг;

2.7."Оюуны бэрхшээлтэй хүн" гэж оюуны хоцрогдолтой буюу санал бодлоо солилцох, хүлээн авч ойлгох, өөрийгөө илэрхийлэх гэх мэт өдөр тутмын асуудлыг сайн ойлгож, хийж чадахгүйн улмаас дэмжлэг шаардлагатай хүнийг;

2.8."Симуляци арга" гэж суралцагчдыг бодит амьдралд ойролцоо нөхцөл байдалд оруулж, тухайн нөхцөлд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх, шийдвэр гаргах, ур чадвараа хэрэглэхийг дадлагажуулах, туршлагажуулах аргыг;

2.9."Ганцаарчилсан сургалт" гэж нэг хүнтэй ганцаарчилж, түүний хувийн амьдрал, сэтгэл зүйн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн сургалтыг;

2.10."Сургалтын хэлбэр" гэж сургалтыг хэзээ, хаана, ямар орчинд, ямар зохион байгуулалтаар явуулах арга замыг хэлнэ.

Гурав. Гамшгаас хамгаалах сургалтын агуулга, арга хэлбэр

3.1.Гамшгаас хамгаалах сургалтын агуулгыг хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүрт тохируулан, дараах үндсэн чиглэлээр боловсруулна.

3.1.1.Гамшгийн тухай ойлголт (газар хөдлөлт, гал түймэр зэрэг);

3.1.2.Өөрийгөө болон бусдыг хамгаалах анхан шатны арга хэмжээ;

3.1.3.Нүүлгэн шилжүүлэх, аюулгүй гарц олох зэрэг үйл ажиллагаа;

3.1.4.Гамшгийн үеийн харилцаа(тусламж дуудах, дохио өгөх зэрэг) мэдээлэл солилцоо;

3.1.5.Сэтгэлзүйн дэмжлэг ба өөрийгөө удирдах(стресс, айдсыг давах зэрэг) агуулгыг тусгаж боловсруулна.

3.2.Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамаарч дараах сургалтын арга хэлбэрүүдийг хослуулан хэрэглэнэ.

3.2.1.танхимын сургалт (онолын мэдлэг, дүрс зураг, тайлбарт танилцуулга)

3.2.2.симуляци (гамшгийн нөхцөл бүрдүүлж оролцогчдын дадлага хийх)

3.2.3.бүлгийн хэлэлцүүлэг (туршлага солилцох, асуулт-хариулт, хамтын шийдэл)

3.2.4.хөдөлгөөнт тоглоом, дасгал (хүүхэд, оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан арга)

3.2.5. Хэрэглээний сургалт (анхны тусламж, амьсгалуулалд, гарц хайх, хэрэгсэл ашиглах биеэр хийж үзэх)

3.2.6.хүртээмжтэй медиа хэрэглээ (Брайл, аудио, дохионы хэл, том шрифт, дүрс бичлэг, зурагт самбар ашиглах)

3.2.7.ганцаарчилсан сургалт (хувь хүнд тохируулсан, ганцаарчилсан чиглүүлэг, дэмжлэгтэй сургалт)

3.3. Гамшгаас хамгаалах сургалтын арга, хэлбэрийг сонгохдоо хөгжлийн бэрхшээлийн төрөл (харааны, сонсголын, хөдөлгөөний, оюуны), нас, боловсролын түвшин, тухайн орчны хүртээмж, аюулгүй байдал, суралцагчийн идэвх, бие даах чадварт анхаарч дараах байдлаар сонгоно.

3.3.1.харааны бэрхшээлтэй хүмүүст тактиль (хүрэлцэх мэдрэхүйд суурилсан) дууны мэдээлэл, баррель үсэг, таних тэмдэглэгээтэй сургалтын;

3.3.2.сонсголын бэрхшээлтэй хүмүүст дохионы хэл, бичмэл материал, видео тайлбартай сургалтын;

3.3.3.хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст нүүлгэн шилжүүлэх, хөдөлгөөний хязгаарлалттай нөхцөлд хийх арга хэмжээний сургалтын;

3.3.4.оюуны бэрхшээлтэй хүмүүст хялбаршуулсан агуулга, давтамжтай, дүрслэлээр ойлгуулах, бодитоор хийж үзэх, хөгжилтэй, тоглоомын хэлбэрээр явуулах сургалтын арга, хэлбэрийг сонгоно.

3.4.Гамшгаас хамгаалах сургалтын өмнө сургалтад хамрагдах зорилтот бүлгийг тодорхойлж, хөгжлийн бэрхшээлийн төрлийг ангилах, оролцогчдын тоо, байршил, онцлогийг судлах, сургалтын орчны хүртээмжийг шалгах, сургалт зохион байгуулах орчуулагч, туслах хамтран явуулах алба хаагч, ажилтныг бэлтгэх, сургалтын хөтөлбөр, хуваарийг боловсруулна.

3.5.Гамшгаас хамгаалах сургалтын агуулгыг боловсролын суурь, дунд, ахисан шатлалтайгаар боловсруулж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллага, алба хаагч, ажилтан хамтран зохион байгуулна.

Дөрөв. Гамшгаас хамгаалах сургалтын хэрэглэгдэхүүн

4.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зохион байгуулах гамшгаас хамгаалах сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэхэд ойлгомжтой, энгийн байх, дүрслэл давамгайлсан байх, тухайн хүний бэрхшээлийн онцлогт нийцэх, олон дахин ашиглагдах боломжтой байх, бодитоор харьцаж болохуйц практик хэрэглээтэй байх, тэсвэртэй, угааж цэвэрлэж болдог байх зарчмыг баримтална.

4.2. Гамшгаас хамгаалах сургалтад дараах хэрэглэгдэхүүнийг ашиглана.

4.2.1.дүрслэлтэй, хялбаршуулсан материал (зурагт карт, алхамчилсан зурагт тайлбар, хялбаршуулсан гарын авлага),

4.2.2.дигитал хэрэглэгдэхүүн (хөдөлгөөнт дүрс бичлэг, аудио заавар, гар утас, таблетын апп),

4.2.3.бодит үзүүлэн, дадлагын хэрэгсэл (аюулгүйн гарцын тэмдэглэгээ, гал унтраах багажийн загвар, анхны тусламжийн иж бүрдэл, симуляци хэрэгсэл),

4.2.4.хүртээмжтэй материал (тусгай хэрэгцээт хүмүүст), тоглоомын хэрэглэгдэхүүн (сургалтын самбар тоглоом, пазель, эвлүүлдэг зураг, дүр бүтээх тоглоомын баг), сургалтын урамшууллын хэрэгсэл (медаль, сертификат, наалт, “чи чадна” карт) ашиглан сургалт зохион байгуулна.

4.3.Харааны бэрхшээлтэй хүмүүст доорх материалыг ашиглан гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулна.

4.3.1.брайль үсгээр хэвлэгдсэн гарын авлага, зааварчилгаа

4.3.2.аудио (дуут) материалууд, дуут болон чичиргээт дохионы симулятор

4.3.3.тактиль (мэдрэхүйгээр таних) материалууд (Гарц, аврах гарцын загвар макет, галын хор, анхны тусламжийн хэрэгслийн загвар, барилгын төлөвлөгөөний 3D загвар)

4.3.4.галын аюулгүй байдлын тактиль самбар ашиглан сургалт зохион байгуулна.

4.4.Сонсголын бэрхшээлтэй хүмүүст доорх материалыг ашиглан гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулна.

4.4.1.дохионы хэлний орчуулгатай видео хичээлүүд

4.4.2.харааны (visual) материалууд

4.4.3.бичгээр боловсруулсан гарын авлага, заавар

4.4.4.гар утасны аппликейшн

4.4.5.сургалтын үзүүлэн, загварууд

4.4.6.сэдрэхүйн сургалтын хэрэгслүүд

4.4.7.хувийн хэрэглээний зориулалттай багц

4.4.8.сургалтын орчны тохируулга

4.4.9.дасгал ажлын хэрэглэгдэхүүн

4.4.10.технологийн дэмжлэг ашиглан сургалт зохион байгуулна.

4.5.Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст доорх материалыг ашиглан гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулна.

4.5.1.танилцуулга, зааварчилгааны материал

4.5.2.видео хичээлүүд

4.5.3.сургалтын орчны зохицуулалт

4.5.4.үзүүлэн, загварууд

4.5.5.дасгал ажлын хэрэглэгдэхүүн

4.5.6.хувийн хэрэглээний зориулалттай багц

4.5.7.технологийн дэмжлэг, автомат дохиолол, мэдээллийн системтэй холбогдох төхөөрөмжүүд, хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүст зориулсан гар утасны аппликейшн (GPS, чичиргээт дохио гэх мэт)

4.5.8.хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст зориулсан нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон туслах хэрэгсэл ашиглан сургалт зохион байгуулна.

4.6.Оюуны бэрхшээлтэй хүмүүст доорх материалыг ашиглан гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулна.

4.6.1.гал, үер, газар хөдлөлт, аюулын дохио, хамгаалах байр зэрэг ойлголтыг энгийн зурагтайгаар харуулах карт

4.6.2.алхамчилсан зурагт тайлбар (жишээ: “гал гарвал юу хийх вэ?” гэсэн 3-5 алхамтай зурагт хуудас)

4.6.3.богино өгүүлбэр, зурагтай тайлбар бүхий ном, хуудас, гарын авлага

4.6.4.аюулгүй байр, гарц, хамгаалах байр зэргийг өнгө, тэмдэглэгээгээр ялгаж үзүүлэх наалт, тэмдэглэгээтэй самбар

4.6.5.яаралтай үед гардаг дохиог урьдчилан танилцуулах дохиоллын дуу авианы төхөөрөмж

4.6.6.гал унтраагчийн дуураймал загвар

4.6.7.сургалтын орчинд бодитоор үзүүлэх, заах нүүлгэн шилжих гарцын тэмдэглэгээ

4.6.8.боолт, маск, бээлий ашиглан үйлдэлд суралцах анхны тусламжийн хэрэгсэл ашиглан сургалт зохион байгуулна.

4.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч буй гэр бүлийн гишүүд, асран хамгаалагчдад доорх материалыг ашиглан гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулна.

4.7.1.гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн тайвшруулах, нүүлгэн шилжүүлэх, заавар өгөх талаарх алхамчилсан тайлбар, гарын авлага

4.7.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр, холбоо барих хүн, хэрэглэдэг эм, төхөөрөмж, ойлгодог дохио, тусгай хэрэгцээ зэргийг тэмдэглэдэг төлөвлөгөөний маягт

4.7.3.биед авч явах зүйлсийн жагсаалт (үнэмлэх бичиг баримт, эмийн бүртгэл гэх мэт)

4.7.4.Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл

4.7.5.галын аюулын сургалтын хэрэгсэл

4.7.6.нүүлгэн шилжүүлэлтийн дадлага гарцын тэмдэглэгээ

- 4.7.7.видео сургалт (хэлбэржүүлсэн кейсүүдтэй)
- 4.7.8.алхамчилсан дүрслэл бүхий PowerPoint хичээл (текст бага, зураг ихтэй)
- 4.7.8.гар утаснаас орж харах боломжтой товч гарын авлага
- 4.7.9.сэтгэлзүйн дэмжлэгийн материал, “эерэг дэмжлэгийн үгс” хуудас
- 4.7.10.өөрийгөө болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тайвшруулах зорилготой амьсгалын энгийн дасгалын карт
- 4.7.11.тест, богино асуулга, дүгнэлтийн ярилцлагын маягт ашиглан сургалт зохион байгуулна.

Тав. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулахад тавигдах шаардлага

- 5.1.Гамшгаас хамгаалах сургалтын орчны шаардлага
 - 5.1.1.хүртээмжтэй орчин (тэргэнцэр, тусгай хэрэгсэлтэй иргэдийн хөдөлгөөнд саадгүй байр налуу зам, өргөн хаалга, бариул гэх мэт)
 - 5.1.2.дуу чимээний зохицуулалт (сонсголын болон оюуны бэрхшээлтэй хүмүүст дуу чимээний цочрол үүсгэхгүй тайван орчин)
 - 5.1.3.гэрэлтүүлэг, харааны тусламж (харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан тод тэмдэглэгээ, контраст өнгө, гэрэлтэй орчин)
 - 5.1.4.суух тав тухтай байрлалт (биеийн болон оюуны бэрхшээлтэй хүмүүст удаан суух боломжтой, зөөлөвчтэй, тулгууртай сандал)
 - 5.1.5.хэрэгцээтэй ариун цэврийн өрөө (тусгай хэрэгцээтэй хүмүүст зориулсан ариун цэврийн өрөө байх)
- 5.2.Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах хүний нөөцийн шаардлага
 - 5.2.1.сургалтын багш, сургагч (хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах арга зүй, харилцааны мэдлэгтэй, туршлагатай байх)
 - 5.2.2.асран хамгаалагч, туслах ажилтан (сургалтын үеэр дэмжлэг үзүүлэх туслах ажилтан, орчуулагч (хэл ярианы/дохионы хэл гэх мэт)
 - 5.2.3.харилцаа ойлголцлын ур чадвар (удирдамжийг энгийн, ойлгомжтой үгээр тайлбарлаж чадах, тэвчээртэй харилцах чадвартай байх)
 - 5.2.4.эерэг хандлагатай баг (сургалтад оролцогчдыг ялгаварлахгүй, дэмжих хандлагатай мэргэжлийн хамт олон шаардлагатай)
- 5.3.Гамшгаас хамгаалах сургалтын агуулгын шаардлага
 - 5.3.1.хөгжлийн бэрхшээлийн онцлог бүрд тохируулсан, энгийн үг, зураг, бодит жишээнд суурилсан тохиромжтой агуулгатай байх
 - 5.3.2.сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангах (цочроох агуулгаас зайлсхийх, тайвшруулах, итгэл төрүүлэх мэдээ, хэлбэр ашиглах)
 - 5.3.3.давтан сануулах, тогтоох арга зүйтэй байх (нэг сэдвийг олон хэлбэрээр тайлбарлах, үйлдлээр үзүүлэх)
 - 5.3.4.хэлбэржүүлсэн, дүрд тоглох арга хэрэглэх (дадлага, симуляц, дүрд тоглох зэргээр мэдлэгийг ойлгуулж, бэхжүүлэх хэлбэр шаардлагатай)
- 5.4.Гамшгаас хамгаалах сургалтын хэрэглэгдэхүүн, техник шаардлага
 - 5.4.1.харааны хэрэглэгдэхүүн ашиглах (зурагт тайлбар, самбар, видео, инфографик, үзүүлэн материал)
 - 5.4.2.сонсголын хэрэглэгдэхүүн ашиглах (Аудио тайлбар, дохионы хэл, текст субтитр бүхий видео)
 - 5.4.3.цахим хэрэглэгдэхүүн ашиглах (гар утсаар ашиглах боломжтой заавар, QR код, аппликейшн)
 - 5.4.4.бодит хэрэглэгдэхүүн ашиглах (гал унтраагч, анхны тусламжийн хэрэгсэл, дохиолол гэх мэт хэрэгслийг гараар барьж үзэх боломжтой байх)
- 5.5.Гамшгаас хамгаалах сургалтын үнэлгээ, урамшууллын шаардлага

5.5.1.оролцогчийн үнэлгээ, танилцуулсан мэдлэгийг ойлгосон эсэхийг энгийн аргаар (зураг сонгох, ярилцах) үнэлэх

5.5.2.идэвхтэй оролцсон оролцогчдод урамшуулал, батламж, наалт, медаль өгөх

5.5.3.сургалтын дараах сэтгэл ханамж, хэрэгцээний үнэлгээ авах (асран хамгаалагчдаас ч багтаана)

5.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүхий л боломж, чадвараа дайчлан илүү бүтээлчээр суралцах нөхцөлийг бүрдүүлж, сургалтыг сонирхолтой хэлбэрээр зохион байгуулна.

5.5.Буруу үг, хэллэг хэрэглэхгүй байх (сохор, дүлий, доголлон, тахир дутуу, өвчтэй, хэлгүй гэх мэтээр) шаардлагатай.

Зургаа. Гамшгаас хамгаалах сургалтын үнэлгээ

6.1.Гамшгаас хамгаалах сургалтын үр дүнг дараах үзүүлэлтээр дүгнэнэ.

6.1.1.сургалтын агуулгыг ойлгосон байдал (товч тест, асуулт, хариулт, зураг сонгуулах, аман ярилцлага, урьдчилсан ба дараах тестээр харьцуулж %-аар, бодит нөхцөлд хэрэглэж чадах эсэх үзүүлэлтээр)

6.1.2.дадлага, туршилтын гүйцэтгэл (аюулгүй гарцын маршрутыг дагаж чадсан эсэх, галын аюулын үед үзүүлэх үйлдлийг гүйцэтгэсэн эсэх, анхны тусламжийн мэдлэгийг ашигласан эсэх үзүүлэлтээр)

6.1.3.харилцаа, ойлголцлын ахиц (дохионы хэл, дүрс, заавар ойлгосон байдал, ойлгомжтой харилцах чадвар дээшилсэн эсэх үзүүлэлтээр)

6.1.4.оролцоо, идэвхийн түвшин (идэвхтэй оролцсон оролцогчдын хувь, хичээлийн турш дадлага, асуултад хариулсан байдал үзүүлэлтээр)

6.1.5.асран хамгаалагчийн чадавх нэмэгдсэн эсэх (хөгжлийн бэрхшээлтэй хүний тусламжийг зохицуулах чадвар, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах чадвар гэсэн үзүүлэлтээр)

6.1.6.сэтгэл ханамж, сургалтын чанарын үнэлгээ (оролцогчийн сэтгэл ханамжийн түвшин, сургалтын чанарын талаарх үнэлгээ гэсэн үзүүлэлтээр)

6.1.7.сургалтын дараах хэрэгжилт, хандлагын өөрчлөлтийг (1-3 сарын дараа хэрэгжүүлсэн өөрчлөлт, гэр бүлийн түвшинд аюулгүй байдлыг нэмэгдүүлсэн эсэх гэсэн үзүүлэлтээр)дунд хугацаанд ажиглах байдлаар дүгнэнэ.

Долоо. Бусад

7.1.Гамшгаас хамгаалах сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчинд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, холбоо, сайн дурынхан, иргэдийн оролцоотой зохион байгуулна.

7.2.Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төсөл, хувийн хэвшлийн хандив, бусад эх үүсвэрийн санхүүжилтээр зохион байгуулна.

7.3.Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрууд сургалт зохион байгуулсан тайлан мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хугацаат тайлан, мэдээг тайлагнах, дүгнэх журам”-д заасны дагуу тайлагнах (гамшгаас хамгаалах ангиллын сургалтын мэдээний Маягт-СМ-1) ба цахим мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР (загвар)

Сэдэв: “Хөгжлийн бэрхшээлтэй хүний гамшгийн үеийн бэлэн байдал”

Сургалтын зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хангах мэдлэг, дадалд сургах, чадавхжуулах.

Хугацаа: 1 өдөр

Оролцогчид: Сонсгол, хараа, хөдөлгөөний хөгжлийн бэрхшээлтэй 30 хүн

Байршил: _____

Зохион байгуулагч: _____

Оролцох багш, сургагчид: _____

Цаг	Сэдэв	Агуулга	Хариуцагч
09:00–09:30	Нээлт	Оролцогчдын бүртгэл, нээлт, сургалтын танилцуулга	Сургалт зохион байгуулагч
09:30–10:15	Гамшгийн төрлүүд ба эрсдэл	Байгалийн болон хүний гаралтай гамшгийн ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх нөлөө	Онцгой байдлын байгууллагын мэргэжилтэн
10:15–10:30	Завсарлага		
10:30–11:30	Гамшгийн үед авах анхан шатны арга хэмжээ	Гэртээ болон нийтийн газар хэрхэн өөрийгөө хамгаалах, тусламж дуудах	Сургагч багш
11:30–12:30	Гэр бүлийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах	Гэр бүлийн гишүүдтэйгээ бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах арга	Сэтгэл зүйч, нийгмийн ажилтан
12:30–13:30	Үдийн завсарлага		
13:30–14:30	Дадлага: Гамшгийн аюулын дохио таних	Гал, газар хөдлөлтийн үед аюулгүй гарц, дохио, тусламжийн хэрэгслийг таних дадлага	Онцгой байдлын байгууллагын
14:30–15:15	Гамшгийн харилцаа холбоо, мэдээлэл авах	Онцгой нөхцөлд мэдээлэл авах эх сурвалж, сонсгол, хараа бэрхшээлтэй хүмүүст зориулсан арга	ICT мэргэжилтэн
15:15–15:30	Завсарлага		
15:30–16:00	Сургалтын үнэлгээ	Хэрэгцээ, ойлголт, сэтгэл ханамжийн үнэлгээний асуулга бөглөх	Сургалтын зохион байгуулагч
16:00–16:30	Хаалт	Гэрчилгээ гардуулах, санал хүсэлт сонсох, зургаа авхуулах	

Тайлбар: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд тохируулан тусгай орчуулга (дохионы хэлмэрч, брайл материал, тусгай тайлбар) шаардлагатай бол урьдчилан бэлтгэнэ.

Хөтөлбөрийг оролцогчдын ачааллыг харгалзан хөдөлгөөний завсарлага, тайван агуулгаар төлөвлөнө.

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (загвар)

Огноо	Цаг	Агуулга	Арга хэлбэр	Хариуцагч
6/10	10:00	Гамшгийн тухай ойлголт	Танхимын сургалт	ОБГ
6/10	11:00	Нүүлгэн шилжих дадлага	Симуляц	Сургалтын баг
6/10	13:00	Харилцаа, тусламж дуудах	Дүрд тоглох	Нийгмийн ажилтан
6/11	10:00	Сургалтын үнэлгээ, санал асуулга	Асуулт хариулт	Багш

СИМУЛЯЦИ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (загвар)

Цаг	Үйл ажиллагаа	Агуулга	Хариуцагч
13:30 – 13:45	Танилцуулга	Газрын хөдлөлтийн тухай богино мэдээлэл:	ОББ-ын төлөөлөл
	– Юу хийх вэ?		
	– Юу хийхгүй вэ?		
	– “Суу–Нуугд–Хүлээ” дасгал ажил		
13:45 – 14:00	Бэлтгэл ажил		Сургалтын зохицуулагч
	– Сургалтын байрны нүүлгэн шилжүүлэх зураглал		
	– Гарцуудын заавар		
	– Тусгай дохионы тайлбар		
	– Дохионы хэлмэрч танилцуулна		
14:00 – 14:15	Симуляц эхлэх дохио		Зохион байгуулагч
	Сэрэмжлүүлгийн дохио дуугарах		
	“Газрын хөдлөлт болж байна!”		
	Оролцогчид “Суу– Нуугд–Хүлээ” аргыг хэрэгжүүлнэ		
14:15 – 14:30	Нүүлгэн шилжүүлэлт хийх		Нүүлгэн шилжүүлэх ажиллагааг хариуцсан баг
	– Галын гарцаар тайван буух		
	– Сургалтын байрнаас нүүлгэн шилжих		
	– Гадаа аюулгүй цэгт цугларна		
14:30 – 14:50	Нийт үнэлгээ, дүгнэлт		Багш, зохицуулагч
	– Хэрхэн ажилласныг дүгнэх		
	– Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сорилт, амжилтыг хэлэлцэх		
	– Асуулт, санал асуулга		
14:50 – 15:00	Гэрчилгээ, гардуулах, зураг авалт		Зохион байгуулагч баг

СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ (загвар)

№	Үнэлгээний шалгуур	Үнэлгээний түвшин (✓ тэмдэглэнэ)		Тайлбар/Санал хүсэлт
		Маш сайн	Сайн	
1	Сургалтын агуулга ойлгомжтой байв уу?			
2	Сургалтын орчин (танхим, тоноглол, дуу чимээ гэх мэт) тохиромжтой байв уу?			
3	Сургалтын арга барил (яриа, дасгал, дадлага) тохиромжтой байв уу?			
4	Таны мэдлэг нэмэгдсэн гэж үзэж байна уу?			
5	Багш, сургагч багшийн хандлага, тайлбар ойлгомжтой байв уу?			
6	Сургалтад оролцсоноор өөрийгөө гамшгаас хамгаалах чадвартай болсон гэж үзэж байна уу?			
7	Сургалт таны хэрэгцээнд нийцсэн үү?			
8	Сургалтаас авсан мэдээллээ гэр бүл, найз нөхдөдөө дамжуулах уу?	Тийм ☐	Үгүй ☐	
9	Цаашид ямар сургалт хэрэгтэй гэж үзэж байна вэ?	—	—	
10	Нэмэлт санал, хүсэлт	—	—	

СУРГАЛТЫН ҮР ДҮНГИЙН ДҮГНЭЛТИЙН ХҮСНЭГТ (загвар)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Үнэлгээ/Үр дүн	Тайлбар
1	Сургалтад хамрагдсан нийт хүний тоо	хүн	30	Хөдөлгөөний бэрхшээлтэй 30 хүн
2	Оролцсон хувь	%	95%	Урьдчилсан бүртгэлтэй 32 хүнээс 30 ирсэн
3	Мэдлэгийн өсөлт (тестийн дундаж оноо)	оноо	40 → 85	Сургалтын өмнө ба дараа авсан онооны зөрүү
4	Гамшгийн үед авах арга хэмжээг ойлгосон хувь	%	90%	Асуулгаар шалгасан
5	Дадлага дасгалд зөв оролцсон хүн	хүн	26	Сайн гүйцэтгэсэн гэж үнэлсэн
6	Хандлага, ойлголтын зэрэг өөрчлөлт	%	88%	Сэтгэл ханамжийн судалгаа
7	Сургалтын орчны хүртээмж	үнэлгээ	Сайн	Тохиромжтой танхим, дохионы хэлмэрчтэй
8	Сургалтын агуулга ойлгомжтой байдал	үнэлгээ	Маш сайн	Судалгаанд 92% нь "ойлгомжтой" гэж хариулсан
9	Сургалтын сэтгэл ханамж	%	93%	28 хүн "сэтгэл хангалуун" гэж хариулсан
10	Цаашид хэрэгжүүлэх санал, хүсэлт	тоо	5	Аймаг, орон нутагт давтан зохион байгуулах, материал тараах